



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ТАТВАРЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 09 сарын 29 өдөр

Дугаар 4/29

Арвайхээр сум

Сургалтын зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Татварын ерөнхий хуулийн 77 дугаар зүйлийн 77.7.3, 77.7.12, Татварын ерөнхий газрын даргын 2023 оны А/110 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Өвөрхангай аймгийн Татварын хэлтсийн Сургалтын зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Сургалтын зөвлөлийн дарга: Захиргаа хуулийн тасгийн дарга А.Ганчимэг
Сургалтын зөвлөлийн нарийн бичгийн дарга: Хуулийн асуудал хариуцсан
татварын улсын байцаагч Б.Бямбасүрэн

Гишүүд: Татварын хяналт шалгалтын тасгийн дарга Т.Бадамхорол
Жижиг татвар төлөгчтэй харилцах тасгийн татварын улсын
байцаагч Л.Буянжаргал

Бичил татвар төлөгчтэй харилцах тасгийн Баянгол сумын
татварын улсын байцаагч Д.Насанжаргал

2. Татварын ажилтан албан хаагчийг чиглүүлэх, мэргэшүүлэх, дадлагажуулах, хөгжүүлэх, тухайн жилийн батлагдсан төлөвлөгөөний дагуу ажлын байрны болон зайн, танхимын хэлбэрээр зохион байгуулж, ажилтан, албан хаагчийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, үнэлж дүгнэн тайлагнахыг сургалтын зөвлөлийн нарийн бичгийн дарга (Б.Бямбасүрэн)-д даалгасугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хуулийн тасгийн дарга (А.Ганчимэг)-т үүрэг болгосугай.



621001041